



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/421

Алтай хот

Техникийн комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211, 2020 оны "Зөвлөмж батлах тухай" 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ГААОНӨГ/202201045 дугаар бүхий Тайшир сумын Агропаркруу цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ татсан ажлыг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж, урьдчилсан дүгнэлт гаргах үүрэг бүхий техникийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	3.Жаргалтуяа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Г.Цоггэрэл (Тайшир сумын Засаг даргын орлогч)
	Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

2.

Д.Отгонжаргал (Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга:Ц.Энхмэнд "Хуруу цахир" ХХК-ийн захирал (гүйцэтгэгч)

2.Барилга байгууламжид техникийн комиссыг гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт, зураг төсөлд нийцүүлэн холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн шалгаж, үр дүнг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ